



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/237

Есөнбулаг сум

Олон Улсын сувилагчдын өдөр зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.7, 11.1.8 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Олон Улсын сувилагчдын өдрийг угтан эрүүл мэндийн салбарын сувилагч, тусгай мэргэжилтний эрдэм шинжилгээний хурал, "Эрүүл мэндийн цагаан толгой боловсруулах" болзолт уралдааныг 2026 оны 5 дугаар сарын 01-08 -ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Эрдэм шинжилгээний хурал, "Эрүүл мэндийн цагаан толгой боловсруулах" болзолт уралдаанд шаардагдах 1,990,000 (Нэг сая есөн зуун ерөн мянга) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

